



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ
2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН НЭГДСЭН ТАЙЛАН



Улаанбаатар хот
2022 он

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2
1.1. Зах зээлийн үнэлгээ	2
1.2. Хөрвөх чадвар	3
1.3. Үнэт цаасны зах зээлийн индексүүд	3
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ	4
2.1. Үнэт цаасны зах зээлийн нийлүүлэлт	4
2.1.1. Хувьцааны арилжаа	5
2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа	6
2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа	7
2.1.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа	7
2.1.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	7
2.2. Үнэт цаасны зах зээлийн эрэлт	8
2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц	8
2.3. Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа	8
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД	10
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ	11
4.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль	11
4.2. Хөрөнгө оруулалтын сангийн журам	11
4.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны журам	12
4.4. Хөрөнгийн зах зээлд гарсан шинэ бүтээгдэхүүн	12
4.5. Үнэт цаасны шимтгэл, хураамж	12
4.6. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа	13
4.6.1. Дэд бүтцийн байгууллагууд	13


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хөгжлийн түвшинг үнэлж, тогтоох хүрээнд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн голлох үзүүлэлтүүдэд дараах индикаторуудыг оруулсан байдаг: зах зээлийн үнэлгээ, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хөрвөх чадвар, хувьцааны индекс.

1.1. Зах зээлийн үнэлгээ


Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2022 оны хагас жилийн байдлаар 4.84 их наяд төгрөг болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.16 хувиар өссөн бөгөөд уг үзүүлэлт ДНБ-ний 11.25 хувийг эзэлж байна.

График 1. ДНБ-д харьцуулсан хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бүрдүүлж байгаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 179 компаниас 30 компанийн зах зээлийн үнэлгээ зах зээлийн үнэлгээний 92.76 хувийг бүрдүүлж байна.


График 2. Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 30 компани



1.2. Хөрвөх чадвар

Дэлхийн банкнаас гаргасан үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын багтдаг ангилал буюу дунджаас бага орлоготой орнуудын хөрвөх чадварын үзүүлэлт 53.6 хувь байгаа¹ бол өндөр орлоготой орнуудын хөрвөх чадварын үзүүлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 98.6 хувь байна.

Монгол Улсын хувьд хувьцааны хөрвөх чадвар энэ оны хагас жилийн байдлаар 2.35 хувь байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.79 пунктээр буурсан байна. Хөрвөх чадварыг тооцохдоо тайлант хугацаанд хийгдсэн хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны дүнг нийт зах зээлийн үнэлгээнд харьцуулж тооцдог бөгөөд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа 5.85 тэрбум төгрөгөөр буурснаас гадна зах зээлийн үнэлгээний өсөлт өндөр байсан тул буурсан үзүүлэлттэй байна.



Хөрвөх чадварын үзүүлэлт олон улсын дундаж үзүүлэлттэй харьцуулахад маш бага түвшинд байгаа нь голчлон хувьцааны төвлөрөлтэй хамааралтай байна.

1.3. Үнэт цаасны зах зээлийн индексүүд

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. Зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компаниас бүрдэж буй ТОП-20 индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 34,891.81 нэгж, доод үзүүлэлт 32,795.68 нэгж, дундаж үзүүлэлт 33,867.24 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 713.33 нэгжээр буюу 2.13 хувиар буурч, **32,795.68 нэгж** болсон байна. Үүнд хөрөнгийн захад бүртгэлтэй “АПУ”, “Ард санхүүгийн нэгдэл”, “Таван толгой”, “Түмэн шувуут” зэрэг ТОП-20 индексийг бүрдүүлэгч дийлэнх компаниудын хувьцааны үнэ оны эхнээс буурч байгаатай холбоотой юм.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-аас 2018 онд үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хамаарах MSE-A болон MSE-B индексийг тооцон гаргадаг болсон. MSE-A индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 12,384.65 нэгж, доод үзүүлэлт 11,622.85 нэгж, дундаж үзүүлэлт 12,140.32 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,980.60 нэгжээр буюу 19.04 хувиар өсөж **12,384.65 нэгж** болсон байна.

Харин MSE-B индексийн дээд үзүүлэлт 11,833.22 нэгж, доод үзүүлэлт 11,432.34 нэгж, дундаж үзүүлэлт 11,643.42 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 208.56 нэгжээр буюу 1.86 хувиар өсөж **11,450.93 нэгж** болсон байна.

¹ Хөрвөх чадварын үзүүлэлт (%)

Индекс	2021.06.30	2022.06.30	Өөрчлөлт
ТОП 20	33,509.01	32,795.68	-2.13%
MSE A	10,404.05	12,384.65	19.04%
MSE B	11,242.37	11,450.93	1.86%


ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

2.1. Үнэт цаасны зах зээлийн нийлүүлэлт

Тайлант хугацаанд нийт 275.94 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн байна. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад өмнөх онуудад зөвхөн хувьцаа, өрийн хэрэгсэл, ЗГҮЦ гэсэн 3 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагддаг байсан бол 2020 онд анх удаа хамтын хөрөнгө оруулалтын сан, 2021 оны 1 дүгээр улиралд хамгийн анхны нийтэд санал болгон гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас амжилттай арилжаалагдсан.

Мөн 2022 оны хагас жилийн байдлаар хувьцааны арилжаа түлхүү явагдсан бөгөөд нийт үнэт цаасны арилжааны 41.20 хувийг хувьцаа, 36.93 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 21.01 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 0.85 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа тус тус эзэлж байна.

График 4. Үнэт цаасны арилжааны хэмжээ /бүтээгдэхүүний төрлөөр/



Нийт үнэт цаасны арилжааны хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.34 дахин буурсан үзүүлэлттэй байна.


Харин хөдөө аж ахуйн биржээр тайлант хугацаанд 5 төрлийн нийт 722 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 105.1 тэрбум төгрөгөөр буюу 85.44 хувиар өссөн байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар бирж нь 84 удаагийн цахим арилжаа зохион байгуулан 722 тэрбум төгрөгийн үнэ бүхий бараа, түүхий эдийн арилжаа хийсэн байна.

2.1.1. Хувьцааны арилжаа

Тайлант улиралд хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй бөгөөд хоёрдогч зах зээлд нийт 113.70 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.05 дахин буурсан үзүүлэлттэй байна.

График 5. Хувьцааны арилжаа



“Монголын хөрөнгийн бирж” ХК-аар тайлант хугацаанд нийт 122 удаагийн үнэт цаасны арилжаа явагдаж, хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 135 хувьцаат компанийн 151 сая ширхэг хувьцааг 114 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Нийт 135 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38 компанийн үнэт цаасны ханш өсч, 91 компанийн үнэт цаасны ханш буурч, 6 компанийн үнэт цаасны ханш тогтмол арилжигдсан байна.

Хувьцааны арилжааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 179 компаниар ангилбал 30 компанийн хувьцааны арилжааны дүн нийт хувьцааны арилжааны 98.73 хувийг бүрдүүлж байна. Үүнд:

Тайлант хугацаанд нийт 122 удаагийн арилжаагаар 135 ХК-ийн 151.09 сая ширхэг хувьцааг 113.69 тэрбум төгрөгөөр арилжсан бөгөөд нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн дүнгийн 44.26 хувийг багцын арилжаа, 42.98 хувийг энгийн арилжаа, 0.22 хувийг бүгдийг нь биелүүлэх эсвэл үл биелүүлэх дуудлага арилжаа /AON/, 12.54 хувийг тендер арилжаа тус тус эзлэж байна.

Нийт 135 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38 компанийн үнэт цаасны ханш өсч, 91 компанийн үнэт цаасны ханш буурч, 6 компанийн үнэт цаасны ханш тогтмол арилжигдсан байна. 2022 оны хагас жилийн байдлаар “Талх Чихэр” ХК-ийн үнэт цаасны ханш 10.8 хувиар өссөн нь хамгийн өндөр өсөлттэй үнэт цаас байсан бол “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн үнэт цаасны ханш 65.5 хувиар буурсан нь хамгийн их буурсан үзүүлэлттэй байна. Харин “АПУ” ХК-ийн борлуулалт 2022 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 28.2%-иар өсөж 391.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 2. Арилжааны хэмжээ хамгийн өндөр 30 компанийн арилжааны үнийн дүн /тэрбум төгрөгөөр/

№	Компанийн нэр	Арилжааны үнийн дүн	№	Компанийн нэр	Арилжааны үнийн дүн
1	“АПУ” ХК	52.53	16	“Богд банк” ХК	0.65
2	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	18.88	17	“Сүү” ХК	0.48
3	“Хөсөг трейд” ХК	14.26	18	“Махимпекс” ХК	0.44
4	“Сентрал экспресс Си Ви Эс” ХК	3.64	19	“Баянгол Зочид Буудал” ХК	0.44
5	“Түмэн шувуут” ХК	2.66	20	“Тэнгэрлиг медиа групп” ХК	0.40

6	“Монос Хүнс” ХК	2.56		“Даваанбулаг” ХК	0.39
7	“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК	2.41		“Крипто Үндэстэн” ХК	0.37
8	“Ард Даатгал” ХК	2.05	21	“Женко Тур Бюро” ХК	0.32
9	“Мандал даатгал” ХК	1.86	22	“Таван толгой” ХК	0.28
10	“Бодь Даатгал” ХК	1.47		“Монгол Шевро” ХК	0.25
11	“Говь” ХК	1.43	23	“Монгол базальт” ХК	0.22
12	“Улсын их дэлгүүр” ХК	1.03	24	“ЛэндМН ББСБ” ХК	0.19
13	“Ард кредит ББСБ” ХК	0.87	25	“МИК Холдинг” ХК	0.19
14	“Инвекор ББСБ” ХК	0.84	26	“Хот Девелопмент” ХК	0.17
15	“Талх чихэр” ХК	0.79	27	“Дархан хөвөн” ХК	0.16
НИЙТ					98.73

2.1.1.1. Багцын арилжаа

Тайлант хугацаанд нийт 15 хувьцаат компанийн 54.36 сая ширхэг буюу 50.32 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий багцын арилжаа хийгдсэн нь нийт хувьцааны зах зээлийн арилжааны 44.26 хувийг эзэлж байна.

Хүснэгт 3. Багцын арилжаа хийгдсэн компаниуд

№	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг /мян. ширхэг/	Үнийн дүн /тэр.бум төг/
1	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	202.02	1,273.38
2	“Ард Даатгал” ХК	748.99	711.55
3	“АПУ” ХК	29,625.64	43,666.25
4	“Бодь Даатгал” ХК	6,666.66	1,092.55
5	“Сентрал экспресс Си Ви Эс” ХК	7,358.53	1,520.57
6	“Даваанбулаг” ХК	1,729.70	392.64
7	“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК	315.28	250.65
8	“Хөнгөн Бетон” ХК	58.33	11.66
9	“Хишиг Уул” ХК	217.06	138.92
10	“Хөвсгөл” ХК	48.69	3.54
11	“Женко Тур Бюро” ХК	4,548.77	300.17
12	“Монгол Шевро” ХК	25.28	250.01
13	“Хот Девелопмент” ХК	2,794.27	167.65
14	“Талх чихэр” ХК	18.00	540.00
15	"Өлзий-Дундговь" ХК	6.80	0.68
ДҮН		54,364.06	50,320.23

2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

Тайлант хугацаанд компанийн бондын арилжаа 101.91 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.08 дахин буурсан үзүүлэлт юм. Үүнээс анхдагч зах зээлд нийт 79.72 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлд нийт 22.20 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийгдсэн байна.

2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсанаас хойших хугацаанд 2022 оны хагас жилийн байдлаар нийт 35 хөрөнгө оруулалтын менежментийн компани тусгай зөвшөөрөл авсан байна.

Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй бөгөөд хоёрдогч зах зээлд нийт 2.34 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

2.1.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн биржээр нийт 722.07 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 105.17 тэрбум төгрөгөөр буюу 17.05 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд дараах 5 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдсан байна. Үүнд:

Зураг 1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа



2.1.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

2022 оны хагас жилийн байдлаар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлд нийт 55.0 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлд нийт 2.99 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийгдсэн байна.

“Омни актив ТЗК” ХХК нь 2022 оны 1 дүгээр сард 5.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан бөгөөд анхдагч болон хоёрдогч зах зээлд нийт 5.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь нийт арилжааны үнийн дүнгийн 4.44 хувийг эзэлж байна

“Симпл ассэт ТЗК” ХХК нь 2022 оны 6 дугаар сард 50.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан бөгөөд анхдагч болон хоёрдогч зах зээлд нийт 50.0 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь нийт арилжааны үнийн дүнгийн 32.03 хувийг эзэлж байна.


2.2. Үнэт цаасны зах зээлийн эрэлт

Тайлант хугацаанд 3,893 данс нээгдэж өссөн дүнгээр нийт 2,435,229 данс нээгдсэн байна. Мөн тайлант хугацаанд 13,171 холболтын данс нээгдэж нийт 483,496 холболтын данс нээгджээ.

2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц

Тайлант хугацаанд нийт арилжаанд дотоодын иргэний хийсэн арилжаа 51.86 хувь, дотоодын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 45.53 хувьд, гадаадын иргэний хийсэн арилжаа 1.65 хувь, гадаадын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 0.97 хувийг тус тус эзэлж байна.

График 7. Хөрөнгө оруулагчдын бүтэц /арилжаанд эзлэх хувиар/



2.3. Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа

Биржийн бус зах зээлийн зохицуулалтыг орчныг тодорхой болгохоор “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Биржийн бус зах зээл нь биржийн зах зээлтэй харьцуулахад мэргэжлийн хөрөнгө оруулагчид оролцдог онцлогтой бөгөөд энэ нь үнэт цаас гаргах гэж буй компаниудад тавигдах шалгуур нь харьцангуй бага байх, үнэт цаас гаргах цаг хугацаа, зардал хэмнэх зэрэг олон давуу талыг олгож байна.

Мөн Инновацийн тухай хуулийн 12¹ дэх заалтын дагуу “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-д холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулан баталсан бөгөөд цаашид гарааны компани хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгон гаргах боломжтой болсон.

Тайлант хугацааны байдлаар биржийн бус зах зээлд нийт 56 үнэт цаас гаргагчийн 555.41 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна.

Хүснэгт 4. Биржийн бус зах зээлийн арилжаа /тэрбум төгрөг/

№	Үнэт цаас гаргагч	Нийт бүртгэсэн дүн /төгрөг/	Амжилттай татан төвлөрүүлсэн
1	"Монкон групп" ХХК	15.00	15.00
2	"Гэрэл финанс" ББСБ	0.50	0.50
3	Бизнес инвестмэнт деволопмент ББСБ	1.00	1.00
4	"Альфа зон" ХХК	20.00	15.00
5	"Тера анлимитед" ХХК	2.00	2.00
6	"Хан" ХХК	3.00	3.00

7	"НВЦ Трейдинг" ХХК	7.00	7.00
8	"Говь" ХК	10.00	10.00
9	Монгол Улсын хөгжлийн Банк	284.91	218.98
10	"Нөмөр Кредит ББСБ" ХХК	2.00	2.00
11	"Кэй Эй Майнинг" ХХК	10.00	3.20
12	"Бичил Глобус Финанс ББСБ" ХХК	9.84	9.84
13	"Ти Ди Би Лизинг" ХХК	15.00	10.00
14	"Хөх Монгол Говь Транс" ХХК	3.00	3.00
15	"Бэрс финанс ББСБ" ХХК	10.00	10.00
16	"Төгс прогресс" ХХК	10.00	0.94
17	"Кредитех СТМ ББСБ" ХХК	1.25	1.00
18	"Төв Азийн зам" ХХК	10.00	4.00
19	"Ашид Капитал ББСБ" ХХК	26.00	26.00
20	"Гацуурт" ХХК	8.00	6.40
21	"Грийн индастри" ХХК	10.00	6.00
22	"Шунхлай" ХХК	50.00	23.95
23	"МИК ОССК" ХХК	150.00	34.00
24	"Инвескор ББСБ" ХК	6.74	6.74
25	"Жи эс би капитал ББСБ" ХХК	2.50	2.50
26	"Таван богд финанс ББСБ" ХХК	4.90	4.90
27	"Нэкст Дистрибьюшн" ХХК	5.00	5.00
28	"Ард лизинг" ХХК	9.99	5.99
29	"Гэрэгэ Системс" ХХК	3.00	2.41
30	"Экспокс" ХХК	10.00	7.50
31	"Эко Кар Центр" ХХК	2.00	1.50
32	"Гэрэл финанс ББСБ" ХХК	0.50	0.50
33	"Ард кредит ББСБ" ХХК	7.00	5.48
34	"Актив Гарден" ХХК	10.00	1.55
35	"Ашид Капитал ББСБ" ХХК	9.00	9.00
36	"Жи Эс Би Капитал ББСБ" ХХК	4.00	4.00
37	"Траст Финанс ББСБ" ХХК	0.50	0.50
38	"Таван богд финанс ББСБ" ХХК	5.10	5.10
39	"Монкон констракшн" ХХК	15.00	3.00
40	"Бичил Глобус Финанс ББСБ" ХХК	3.00	2.00
41	"Соно Финтек ББСБ" ХХК	3.90	
42	"Автоланд Эс Си" ХХК	2.00	2.00
43	"Смарт Дийл" ХХК	1.00	1.00
44	"Ори Студиос" ХХК	1.00	
45	"Нөмөр кредит ББСБ" ХХК	4.50	
46	"Мастер түншлэл" ХХК	5.20	5.20
47	"Таван богд финанс ББСБ" ХХК	5.00	2.00
48	"Мони Маркет Фанд" ХХК	2.00	2.00
49	"Хүрэн толгой Коал майнинг" ХХК	31.21	5.00
50	"Ти Ди Би Лизинг" ХХК	20.00	
51	"Степпе Бэвэриж" ХХК	57.69	57.69
52	"Нэткапитал авто" ХХК	10.00	
53	"Хан Алтай ресурс" ХХК	45.00	

54	“Булл Кадитал ББСБ” ХХК	2.20	
55	“Номин трейдинг” ХХК	10.00	
56	“Бизнес инвестмэнт деволопмент ББСБ” ХХК	3.00	
Нийт		960.45	555.41

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Компанийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хууль болон бусад холбогдох дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж байна.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан 164, үнэт цаасаа бүртгүүлсэн 314 ХК, хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг нь бүртгэсэн 29, үнэт цаасны зах зээлд хууль, үнэлгээ, аудитын үйлчилгээ үзүүлэх этгээдээр бүртгүүлсэн 103 этгээд байна.

Хүснэгт 5. Үнэт цаасны зах зээлд оролцогчид

№	Үйл ажиллагааны төрөл	Тоо
Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа		
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	2
2	Үнэт цаасны төлбөр тооцооны байгууллага*	2
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	35
5	Хамтын хөрөнгө оруулалтын сан /хаалттай, нээлттэй/	4
6	Кастодиан банк	3
7	Үнэт цаасны компани /брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх/	58 ¹
8	Хөрөнгө итгэмжлэн удирдах	7
9	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч	1
10	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах	40
11	Хөдөө аж ахуйн бирж	1
12	Хөдөө аж ахуйн брокер	10
13	Өөрийгөө зохицуулах байгууллага*	2
Хувийн ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэн		
14	Хувийн ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгээ бүртгүүлсэн	29
Бүртгэлтэй ХК-ийн тоо		
15	Хувьцаат компани	314
16	Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй*	179
Бүртгэлтэй хөндлөнгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд		
17	ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх	46
18	ҮЦЗЗ-д оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх	22
19	ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх	35
Нийт		581

¹Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 банк орсон болно.

*Давхардсан тоо

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны эхний улирлын байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлд голчлон анхаарч дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

4.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль

Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 52 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль эрх зүйн орчинд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий” ажлын хэсгийн зүгээс “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хорооны цахим хуудсанд байршуулан олон нийт болон мэргэжлийн байгууллагуудын холбогдох саналыг аван, хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсний дараа 2022 оны Улсын Их Хурлын хаврын чуулганд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

4.2. Хөрөнгө оруулалтын сангийн журам

Улсын Их Хурлаас 2013 онд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг баталснаас хойших хугацаанд Хорооны зүгээс хөрөнгө оруулалтын менежментийн компани, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан журмуудыг батлан мөрдүүлж байгаа бөгөөд олон улсын санхүүгийн зах зээлд хамтын сангийн үйл ажиллагаанд гарч буй зохицуулалтын өөрчлөлт, сангийн хөгжлийн шинэ хандлага, зах зээлийн нөхцөл байдал болон өөрийн орны онцлог, гадаад, дотоодын зөвлөхүүдээс хөрөнгө оруулалтын санг хөгжүүлэх чиглэлээр өгч байсан зөвлөмжид үндэслэн холбогдох журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулж, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох шаардлага тулгарч байсан.

Үүнтэй холбогдуулан Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагын хүрээнд хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой 5 журмыг нэг журмын төсөлд нэгтгэсэн бол хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаатай холбоотой 2 журмыг нэг журмын төсөлд нэгтгэсэн. “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ын төсөл, “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын төслийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуультай нийцүүлж, хууль болон журмын зохицуулалтын зөрүүг арилгаж, хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, баримт бичгийг бүртгүүлэх, тавигдах нөхцөл, шаардлагатай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулж, хялбаршуулах замаар журмын төслүүдийг боловсруулж, тус журмуудыг Хорооны 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 275, 276 дугаар тогтоолоор тус тус баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 5850, 5851 дугаарт тус тус бүртгэсэн.

4.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны журам

Хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх ажлын хүрээнд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах болон үнэт цаасжуулалттай холбоотой олон улсын зохицуулалт, хөгжингүй орнуудын туршлагыг судалж, зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн шинэлэг зохицуулалтыг нэмэлт, өөрчлөлтөөр оруулахаар ажиллаж байна. Үүнтэй холбогдуулан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын төслийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, зах зээлийн нөхцөл байдал, өөрийн орны онцлогтой нийцүүлж боловсруулсан бөгөөд Хорооны 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 360 дугаар тогтоолоор баталсан.

4.4. Хөрөнгийн зах зээлд гарсан шинэ бүтээгдэхүүн

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад өмнөх онуудад зөвхөн хувьцаа, өрийн хэрэгсэл, ЗГҮЦ гэсэн 3 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагддаг байсан бол 2020 онд анх удаа хамтын хөрөнгө оруулалтын сан, 2021 оны 1 дүгээр улиралд хамгийн анхны нийтэд санал болгон гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас амжилттай арилжаалагдсан.

Санхүүгийн зохицуулах хорооноос шинэ бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх тал дээр онцгой анхаарал хандуулж, бодлогоор дэмжсэний үр дүнд 2022 оны хагас жилийн байдлаар 13 шинэ бүтээгдэхүүн /2020-2022 онд нийт 44 шинэ бүтээгдэхүүн/ гараад байгаа бөгөөд үүнд 2 нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцаа /“Волтам” ХХК, “Мон бийф” ХХК/, 1 компанийн хаалттай өрийн хэрэгсэл /“Ард кредит ББСБ” ХК/, 3 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /“Омни актив ТЗК” ХХК, “Симпл ассет ТЗК” ХХК, “ҮЦСК актив гурав” ХХК/, 2 хаалттай хүрээнд нэмж гаргасан энгийн хувьцаа /“Блюскай секьюритиз ҮЦК” ХК, “Тандэм инвест ББСБ” ХК/, 2 нээлттэй хүрээнд нэмж гаргасан энгийн хувьцаа /“Эрдэнэс сольюшинс” ХК, “Инвескор ББСБ” ХК/, 1 өрийг хувьцаагаар солих зорилгоор хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцаа /“Шарын гол” ХК/, 2 хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сан /“Мандал ассет менежмент ҮЦК” ХХК, “Ард менежмент ҮЦК” ХХК/-г тус тус бүртгээд байна.

4.5. Үнэт цаасны шимтгэл, хураамж

Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн 4.1 дэх хэсэгт заасан “Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийг бууруулах” арга хэмжээний хүрээнд үнэт цаасны арилжааны шимтгэл, хураамжийг бууруулж, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, зах зээлд оролцогчдыг дэмжихтэй холбогдуулан бодлого, зохицуулалтын дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн:

1. 2022 оны 2 дугаар улиралд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-д хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1 хувь байсныг нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн хэмжээнээс хамааруулан хязгаар тогтоож, 50-75 хувиар бууруулан 0.25-0.5 хувь болгосон. Мөн жилийн үйлчилгээний хөлсний хэмжээ сангийн цэвэр хөрөнгийн дүнгийн 0.1 хувь байсныг 50 хувиар бууруулж 0.05 хувь болгосон.
2. 2022 оны 2 дугаар улиралд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Бүртгэлийн журам”-д хувьцааг бүртгэх үйлчилгээний хөлс нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 0.1

хувь байсныг үнийн дүнгээс хамааруулан 20-40 хувиар бууруулан 0.06-0.08 хувь болгосон. Мөн өрийн хэрэгсэл бүртгэх үйлчилгээний хөлс үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлбэл зохих мөнгөн хөрөнгийн 0.1 хувь байсныг үнийн дүнгээс хамааруулан 0-36 хувиар бууруулан 0.064-0.1 хувь болгосон.

2022 оны 2 дугаар улиралд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Арилжааны журам”-д хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжаанд худалдсан тал шимтгэлгүй байх, түүнчлэн худалдан авсан талын хувьд хэлцлүүдийн үнийн нийлбэр дүнгээс хамааруулан шимтгэлийг тооцдог байхаар зохицуулалтыг тусгасан бөгөөд тус журмыг Хорооны 2022.06.21-ны 335 дугаар тушаалаар батламжилсан.

4.6. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

4.6.1. Дэд бүтцийн байгууллагууд

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 330 тоот тушаалаар Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүсэж, “Монголын Хөрөнгийн Бирж” ХК үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан билээ. Энэ хүрээнд Хөрөнгийн зах зээлийн 30 жилийн ойг тохиолдуулан “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК болон "Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо" ГҮТББ-тай хамтран үнэт цаас гаргахаар сонирхож байгаа аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд урт хугацаат хямд өртөг бүхий хөрөнгийг олон нийтээс хэрхэн амжилттай татан төвлөрүүлэх, үнэ цэнээ өсгөх, цаашид гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг хэрхэн татах, тэдний итгэлийг хүлээсэн сайн засаглал бүхий хариуцлагатай компанийг бий болгох, тогтвортой өсөж хөгжих бодит боломжийг таниулах зорилгоор “IPO Mongolia 2022 Forum - Хүртээмжтэй хөрөнгийн зах зээл” арга хэмжээг 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан.

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР